



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 4 дүгээр
сарын 27-ны өдөр


Дугаар 165

Улаанбаатар
хот

Гадаадаас ажиллах хүч,
мэргэжилтэн авах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2015 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид зохих журмын дагуу олгохыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт зөвшөөрсүгэй.
2. Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.
3. Мэргэжилтэй ажиллах хүчинийг дотоодод сургаж бэлтгэх, мэргэжлийн өндөр ур чадвартай гадаадын мэргэжилтнийг дагалдуулан мэргэшүүлэх арга хэмжээ авч, уг үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хөдөлмөрийн сайд

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2015 оны 165 дугаар тогтоолын хавсралт

**2015 ОНД МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХҮЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний төо
Авто замын салбарт			
1	"Шинжаан шинфа" ХХК	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,5 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх	450
2	"Жиансу Жунжиан Жианшин" ХХК	Ховд аймгийн Булган-Үенч-Ховд чиглэлийн 60 км авто замын ажил гүйцэтгэх	200
3	"Хурдны зам" ХХК	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км, Элсэн тасархай-Хархорин чиглэлийн 77 км авто замын ажил гүйцэтгэх	100
4	"Чайна гео инженеринг" корпораци	Өндөрхаан-Чойбалсан чилэлийн 50 км авто замын барилгын ажил гүйцэтгэх	50
Газрын тосны салбарт			
5	"Петро Чайна Дачин Тамсаг Монгол" ХХК	Дорнод аймгийн Тамсагийн сав газрын XIX, XXI гэрээт талбайд газрын тостой холбоотой ажил гүйцэтгэх	800
6	"Эн Пи Ай" ХХК	Дорнод аймгийн "Хөх нуур-XVIII" гэрээт талбайд өрөмдлөг, 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, цооногийн туршилтын ажил гүйцэтгэх	100
Уул уурхай, эрчим хүчний салбарт			
7	"Асгат-Эрдэнэ" ХХК	Төв аймгийн Заамар суманд алтны шороон ордыг ашиглах ажил гүйцэтгэх	50
8	"Машин инженеринг корпораци" компани	Баянзүрх дүүргийн 8, 10 дугаар хороог хамарсан "Ус-15" байрлалд баригдах "Амгалан дулааны цахилгаан станц"-ын угсралтын ажил гүйцэтгэх	200
Барилгын салбарт			
9	"Алтанзурлага" ХХК	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороонд худалдаа, үйлчилгээ, оффисын барилгын ажил гүйцэтгэх	120
10	"Амар амгалан харш" ХХК	Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд "Буман өлзий" хотхон, 600 хүүхдийн 2 цэцэрлэг, 3 давхар 4 үйлчилгээний төв, 5 давхар 50 орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	300
11	"Батсуварга" ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд "Эгэл гарден" орон сууц, үйлчилгээний төв, хүүхдийн цэцэрлэг бүхий цогцолбор, кино театрын барилга, Нүхтийн аманд аялал жуулчлалын цогцолбор, Баянзүрх дүүргийн 18 дугаар хороонд "Х" орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	150

12	"Бойкинс констракшн" ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд "Ногоон цэцэрлэгт жим" ХХК-ийн "Блю Скай Резиденс" хотхоны 20 давхар 2 орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	60
13	"Болор- Өргөө" ХХК	Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд "Буянт-Ухаа" орон сууцны цогцолбор барилгын ажил гүйцэтгэх	150
14	"Бриллиантхаус" ХХК	Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороонд 240 айлын 16 давхар барилга, Баянгол дүүрэгт "Эрин хотхон" хорооллын A2, B2 барилгын ажил гүйцэтгэх	60
15	"Булбул" ХХК	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд "Кэй энд Ти констракшн" ХХК, "Цагаан хуаран констракшн" ХХК-ийн захиалгаар 12 давхар 9 орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	50
16	"Бүрд констракшн" ХХК	Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороонд А блокын 2650 айлын 8 орон сууц, үйлчилгээний 2 төв, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх	60
17	"Биелэхчин хүсэл" ХХК	Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд 288 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	40
18	"Би Би Ай Ай" ХХК	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд "Макс өргөө" ХХК-ийн захиалгаар "Хийморь 13" 360 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	150
19	"Биндэrmөнх" ХХК	Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд "Палас" ХХК-ийн захиалгаар "ПАЛАС" зочид буудлын барилгын ажил гүйцэтгэх	80
20	"Бэлчирконстракшн" ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд "Инэл" компанийн 288 айлын орон сууц, Баянгол дүүргийн 20 дугаар хороонд "Эрин хотхон" хорооллын барилгын ажил гүйцэтгэх	200
21	"Бээжин констракшн инженеринг групп" ХХК (БСИЖМН)	МООНРТ-ийн орчимд баригдах хорооллын инженерийн шугам сүлжээний болон YII, XIY хорооллын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	200
22	"Вистагрупп" ХХК	Баянзүрх дүүргийн 15 хороололд "Сошиал Медиа Солюшн" ХХК-ийн 12 давхар үйлчилгээ, оффисын барилгын ажил гүйцэтгэх	100
23	"Дархан ээж шүтээн" ХХК	Дархан-Уул аймгийн Дархан сумын 10 дугаар хороололд оюутны байрны барилгын суурь, угсралт, зоорь, 5 давхар барилгын карказ, Орхон аймгийн Баян-Өндөр суманд зоорь болон 4 давхар барилга угсралтын ажил гүйцэтгэх	80
24	"ДОЛТ интернэшнл" ХХК	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд "Гүнж" хотхон, 26 дугаар хороонд "Тайгам алтай" ХХК-ийн "Олимп хотхон"-ы 16 давхар 1800 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	300

25	“Дэвших оргил эрдэнэ” ХХК	Хурд группын “ХҮННҮ-2222” хорооллын төсөлд гэрээгээр барилгын ажил гүйцэтгэх	40
26	“Жаксстоун” ХХК	Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд “Залуу монгол” ХХК-ийн захиалгаар “Палас” зочид буудлын барилгын ажил гүйцэтгэх	100
27	“Жиди” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 7 дугаар хорооны Б2, В, Г1 блокын барилгын ажил гүйцэтгэх	80
28	“Жинлүнжин” ХХК	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороонд “21-р зуун” хотхоны 852 айлын 3 блок орон сууцны 12 давхар барилгын ажил гүйцэтгэх	50
29	“Заг” ХХК	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд 7 дугаар хорооллын 6 давхар худалдаа, үйлчилгээний төв, 890 айлын орон сууц, цэцэрлэг, 12 давхар оффис, үйлчилгээний болон 24 давхар орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	60
30	“Зунбоо” ХХК	Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд “Хот байгуулалтын групп” ХХК-ийн “Метрополис” хотхоны 12; 16 давхар барилга, 13 дугаар хороонд “Нью Тур Сафарис” ХХК-ийн үйлчилгээний төвийн барилгын ажил гүйцэтгэх	280
31	“Их-Өргөө” ХХК	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, “Сансар” хотхонд 1430 айлын орон сууц, 240 хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн барилгын ажил гүйцэтгэх	280
32	“Лидер скай” ХХК	Баянзүрх дүүргийн 1, 15 дугаар хороонд “Түү Скай” ХХК-ийн 15 давхар орон сууц, “ЛЖК” ХХК-ийн үйлчилгээ бүхий 19 давхар орон сууцны барилга, угсралтын ажил гүйцэтгэх	150
33	“Легато” ХХК	Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд “Саншайн виллиж” хорооллын Е блокын барилгын ажил гүйцэтгэх	100
34	“Мастер-инженеринг” ХХК	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд 16 давхар эмнэлэг, орон сууц, оффисын барилга, 14 дүгээр хороонд 10 давхар үйлчилгээний төвийн барилгын ажил гүйцэтгэх	50
35	“Монголиа Жун Жиэн Цай” ХХК	“Мөнхийн Баянгал” ХХК-ийн цементийн үйлдвэрийн барилга угсралтын ажил гүйцэтгэх	150
36	“Моннис урбан девелопмент” ХХК	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд 2000 айлын орон сууц, 300 ортой хүүхдийн цэцэрлэг, үйлчилгээний төвийн цогцолбор барилгын ажил гүйцэтгэх	250
37	“Онвард” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар”-ын орон сууцны хороолол барих ажил гүйцэтгэх	90

38	“Өгөөмөр хурд” ХХК	Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хороололд “Шинэ сансар” хорооллын 1500 айлын барилгын ажил гүйцэтгэх	190
39	“Өлзийт буян өргөө” ХХК	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд “Бэрэн” группын 7 дугаар хорооллын барилга, Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд 12 давхар 144 айлын 2, 12 давхар 66 айлын 3 орон сууц, 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх	150
40	“Пи Ай Эм Эм” ХХК	“Голомт констракшн” ХХК-ийн “Шинэ яармаг” төслийн эхний ээлжийн 576 айлын орон сууцны барилга барих туслан гүйцэтгэгчийн ажил	96
41	“Прогресскастелл” ХХК	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд бүрэн цутгамал 160 айлын 16 давхар барилгын ажил гүйцэтгэх	120
42	“Роял ньюкэстл” ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд барилгажих төслийн барилгын ажил гүйцэтгэх	60
43	“Рэнхэжужин” ХХК	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд “Анд интернейшнл” ХХК-ийн 720 айлын орон сууц, “МАК” ХХК-тай гэрээгээр барьж байгаа Тэрэлж дэх 5 одтой зочид буудлын цогцолборын барилгын ажил гүйцэтгэх	120
44	“Сайнболд сайн” ХХК	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд 622 айлын орон сууц, Баянзүрх дүүрэгт “Түмэн Амгалан” хорооллын барилгын ажил гүйцэтгэх	500
45	“Солонгоцамхаг” ХХК	Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд “Гачуурт” 288 айлын, Өвөрхангай аймгийн Хархоринд 30 айлын, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд “АЗИЙН ЭРИН” ХХК-ийн 190 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	60
46	“Таванталст оргил” ХХК	Өвөрхангай аймгийн Хужирт суманд “Хужирт тур” ХХК-ийн Амралт сувиллын цогцолборын барилгын ажил гүйцэтгэх	120
47	“Ти Эм Эл Констракшн” ХХК	Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд “Нью Гор” ХХК-ийн 234 айлын орон сууц, 11 дүгээр хороонд “Жэй Эн Моторс Тур” ХХК-ийн аялал жуулчлалын “Гүйст Хаус” 48 айлын хаусын барилга, үйлчилгээний төв болон автомашины зогсоол, 8 дугаар хороонд “Отгонтэнгэр групп” ХХК-ийн “Буянт Энгэр” үйлчилгээний төв, Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд “Авецина” ХХК, иргэн Г.Батмөнхийн “Хос Өргөө” 37 айлын орон сууцны цогцолбор барилгын ажил гүйцэтгэх	60

48	“Тоб групп” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд “Шинэ хөтөл-28” хороолол, 100 хүүхдийн цэцэрлэг бүхий цогцолбор хорооллын барилгын ажил гүйцэтгэх	50
49	“Төв морьт хангай” ХХК	Сонгинохайран, Баянзүрх дүүрэгт баригдах орон сууцны хорооллын 250000 м ² талбайд барилгын ажил гүйцэтгэх	44
50	“Тэгштэнүүн Мөрөн” ХХК	Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, 4 дүгээр цахилгаан станцын зүүн урд “Ирээдүй” хорооллын 384 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	70
51	“Тэнгисийн баян бүрд” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд “NYC” ХХК-ийн 9 давхар 72 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	100
52	“Их орчлон өргөө” ХХК	Баянзүрх дүүрэгт “Олимп” хотхоны 2 дугаар ээлжийн барилга, “Альфа моторс” ХХК-ийн 1028 айлын орон сууцны барилга барих туслан гүйцэтгэгчийн ажил	400
53	“Халла Гонсол” ХХК	Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд “Шинэ хотын захирагааны төсөл”-ийн барилгын ажил гүйцэтгэх	70
54	“Эм Ар Эйч констракшн” ХХК	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороонд 504 айлын орон сууц, 12 дугаар хороонд Чулуун овоотын барилгажилт төслийн барилгын ажил гүйцэтгэх	70
55	“Эрин-интернэшил” ХХК	“Эрин хороолол” орон сууцны цогцолбор барилгын ажил гүйцэтгэх	100
56	“Энхбагана констракшн” ХХК	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд “Дэрэн наран” ХХК-ийн захиалгаар оффис, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 13 дугаар хороололд 12 давхар үйлчилгээний төв бүхий орон сууцны барилгын ажил гүйцэтгэх	120
57	“Ээл-Үндрам” ХХК	Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар баригдах 320 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх	180